



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/385

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Бичигт багийн нутагт байрлах, үйлчилгээний зориулалттай "Хаш түлхүүр" ХХК /2684489/-ийн эзэмшлийн 8280.0 метр квадрат газраас, газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Хаш-Эрдэнийн Мандах /ПЮ77012267/-д 966.0 метр квадрат газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтгаар, хаягийг Г.Аюурзана 1 дүгээр гудамжны 107 а тоот болгон, үлдсэн 7314.0 метр квадрат газрыг "Хаш түлхүүр" ХХК /2684489/-д үйлчилгээний зориулалтаар хаягийг Г.Аюурзана 1 дүгээр гудамжны 109 тоот болгон 15 жилийн хугацаагаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлж газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг дээрх иргэн, аж ахуй нэгжид үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэн, аж ахуй нэгжтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/385 Ch

02 01905